

БАТЛАВ
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.АЛТАН-ОД

ATA12939 6806232 9024070591

“ДИЖИТАЛ ХОТ (DIGITAL CITY) ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 10 дугаар сарын 17

Дугаар: ЦХХХЯ/20240603201

Улаанбаатар хот

А.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1	Захиалагч байгууллага	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
2	Үндэслэл	<p>Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “АЛСЫН ХАРАА-2050”, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:</p> <p>2.4.4.Шинжлэх ухаан, инновацын салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож, гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ.</p> <p>2.4.11.Тоон технологи ашиглан мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацын үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр:</p> <p>4.2.2.4.Төрийн тогтолцооны цахим дэд бүтцийг хөгжүүлж, шийдвэр гаргах үйл явцыг хурдан, ил тод, нээлттэй болгоно.</p> <p>4.4.4.10.Эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгаас хамгаалах удирдлага, үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий гамшгийн зураглал, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах тогтолцоог хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.</p>
3	Зорилго	Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын нийслэл болон бусад аймаг, хотуудын өмнө хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлуудад контент анализ хийж дижитал хотыг үүсгэх нөхцөл байдлын шинжилгээг хийнэ.
4	Оролцогч тал	<ul style="list-style-type: none">- Судалгааны байгууллага- Технологи, мэдээллийн технологийн компани- Салбарын төрийн болон төрийн бус байгууллага
5	Хамрах хүрээ	<ul style="list-style-type: none">- Улаанбаатар хот- Аймаг- Сум
6	Хүлээгдэж буй үр дүн	<p>Хот, тосгон, аймаг нийслэлийн хэмжээнд ихэр хот “twin city” үүсгэх төслийн суурь судалгаа бий болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Дижитал хот төслийн суурь судалгааны тайлан• Бусад холбогдох тооцоолол

Б.ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

№	Гүйцэтгэх ажил	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Дижитал хотыг бий болгоход шаардагдах судалгааны ажлын бүрдэл иж	<p>Судалгааны ажлын хамрах хүрээг дараах байдлаар авч үзнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлагыг уялдуулж тооцоолох, шаардлагатай эрх зүйн зохицуулалтын санал боловсруулах; 2. Дижитал хот бий болгох стратеги, бодлогыг тодорхойлох; 3. Ерөнхий зураглал боловсруулах <ul style="list-style-type: none"> • Дижитал хотыг хөгжүүлэх оролцогч талуудыг тодорхойлох (Улаанбаатар хот, аймаг, сум); • Төслийг хэрэгжүүлэх хугацаа (Улаанбаатар хот, аймаг, сум) • Оролцогч талуудын үүргийн хувиарлалт, хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт (Улаанбаатар хот, аймаг, сум) • Дэд бүтцийн судалгаа 4. Эдийн засгийн судалгаа <ul style="list-style-type: none"> • Дижитал хотыг бий болгоход шаардагдах санхүүгийн тооцоо (Улаанбаатар хот, аймаг, сум); 5. Олон улсын судалгаа <ul style="list-style-type: none"> • Гаднын улс орнуудын дижитал хот бий болгосон түүхэн нөхцөл байдал, хөгжлийн стратегийг бодитоор харж дүгнэх, судлах; 6. Хөрөнгө оруулалтын тооцоо, эх үүсвэр <p>Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын тойм хэмжээ, боломжит эх үүсвэрүүд, үйл ажиллагааны график төлөвлөгөө, харгалзах зардал, санхүүжилтийг тодорхойлно.</p>

В.ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

	Ерөнхий шаардлага	Тусгай шаардлага
1	Гүйцэтгэгчид тавигдах тусгай шаардлага	<p>Байгууллагад тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага байх; • Системийн динамик загвар 5-аас доошгүйг боловсруулж байсан ажлын туршлагатай байх, ижил төстэй судалгааны ажил гүйцэтгэсэн байх; • Загвар боловсруулах програм хангамж нь албан ёсны зөвшөөрөл буюу лицензтэй байх; <p>Багийн гишүүдэд тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> • Зөвлөх багийн удирдагч нь математик, статистик, математик загварчлалын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх; • Багийн гишүүд нь системийн динамик загварчлалын чиглэлээр эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэсэн туршлагатай байх; • Систем динамик загварчлал, газарзүйн мэдээллийн систем, програм хангамж, дижитал хот гэх мэт чиглэлээр 3-аас дээш жилийн ажлын туршлагатай магистр буюу түүнээс дээш зэрэгтэй байх;
2	Тайланд тавих шаардлага	Гүйцэтгэгч Б хэсэг заасан ажлыг бүрэн гүйцэтгэж, тайланг цахим болон цаасан хэлбэрээр захиалагчид хүлээлгэн өгч, гэрээ дүгнэсэн акт үйлдснээр ажил дуусгавар болно.

ХЯНАСАН:


ЦАХИМ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГА

Б.БАТ-ӨЛЗИЙ

БОЛОВСРУУЛСАН:

ЦЗХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ГЭРЭЛМАА

Handwritten signatures in black ink. The signature on the right is a large, stylized 'H' shape, corresponding to B. Bat-Olzii. The signature on the left is a smaller, more fluid signature, corresponding to B. Gerelmaa.